**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# ДАРХАН-УС СУВАГ ХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**АУДИТЫН КОД:** ДАА-2024/14/НА-СТА-ОНА

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2024 он | Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр<br>Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Батсүрэн<br>Утас: 70373089 Цахим хаяг:<br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 70373089 Цахим хаяг:<br>Аудитор: Ч.Гантулга<br>Утас:70373089 Цахим хаяг: gantulgachu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бүрэнтогтох гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45050,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 146

танай ______ -ны № ______ -т

"ДАРХАН-УС СУВАГ" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЭРДЭНЭБАТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан-Ус суваг" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Дархан-Ус суваг" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийлгэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт гаргах үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2023 оны 37, 59 дугаар тогтоолуудаар улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1,054,903.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсныг санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2022 оны 189 тоот тогтоолоор үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг 25 хувь, 2023 оны 110 тоот тогтоолоор айл өрхийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг 50 хувь нэмэгдүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Компанийн жилийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 79 хувьтай тайлагнасан бө хэрэгжих шатандаа 4, огт хэрэгжээгүй 3 арга хэмжээ байна.

009070762

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлох, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1.1 | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 21,155,984.72 | 96,529,924.00 |
| 1.1.2 | Дансны авлага | 389,750,304.78 | 507,881,949.05 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 20,564,691.89 | 9,447,870.50 |
| 1.1.4 | Бусад авлага | 265,997,710.60 | 241,481,740.30 |
| 1.1.6 | Бараа материал | 307,036,456.15 | 312,038,776.43 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал тооцоо | 48,530,000.00 | 48,530,000.00 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | - | 6,005,542,924.80 |
| 1.1.11 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **1,053,035,148.14** | **7,221,453,185.08** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 23,500,534,431.36 | 22,041,329,590.05 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 9,218,674,139.06 | 9,263,956,339.38 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| 1.2.10 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **32,720,808,570.42** | **31,306,885,929.43** |
| 1.3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **33,773,843,718.56** | **38,528,339,114.51** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 493,532,049.59 | 231,472,642.98 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 88,118,340.71 | 93,092,352.21 |
| 2.1.1.3 | Татварын өр | 160,694,870.73 | 152,663,279.45 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | - | - |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 11,546,875.39 | 9,969,880.05 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 26,265,081.75 | 21,716,662.00 |
| 2.1.1.13 | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **780,157,218.17** | **508,914,816.75** |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 118,631,538.01 | 6,005,542,924.80 |
| 2.1.2.6 | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **118,631,538.01** | **6,005,542,924.80** |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | **898,788,756.18** | **6,514,457,741.55** |
| 2.3.1 | Төрийн өмч | 3,384,431,409.00 | 3,384,431,409.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 10,852,895,172.91 | 11,609,461,293.02 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 35,824,336,162.76 | 36,879,239,437.22 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (17,186,607,782.29) | (19,859,250,766.28) |
| 2.3.11 | **Эздийн өмчийн дүн** | **32,875,054,962.38** | **32,013,881,372.96** |
| 2.4 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **33,773,843,718.56** | **38,528,339,114.51** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1.1 | **Үндсэн үйл ажиллагааны орлого** | **-** | **-** |
| 1.1.1 | Борлуулалтын орлого | 7,100,782,803.60 | 8,403,577,411.95 |
| 1.1.20 | Борлуулалтын орлогын дүн | 7,100,782,803.60 | 8,403,577,411.95 |
| 1.2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 7,279,314,280.34 | 8,462,733,238.32 |
| 1.3 | Нийт ашиг алдагдал | (178,531,476.74) | (59,155,826.37) |
| 1.4.1 | Цалин хөлс, шагнал | 1,002,122,927.24 | 1,087,498,481.00 |
| 1.4.2 | Нийгмийн даатгалын шимтгэл | 156,338,564.30 | 176,736,316.00 |
| 1.4.4 | Ашиглалтын зардал | 33,922,450.42 | 14,352,639.00 |
| 1.4.6 | Албан томилолтын зардал | 5,745,980.50 | 15,879,789.00 |
| 1.4.8 | Түүхий эд материалын зардал | 61,370,388.77 | 70,537,756.00 |
| 1.4.9 | Элэгдлийн зардал | 172,614,273.16 | 176,362,604.00 |
| 1.4.10 | Зар сурталчилгааны зардал | 3,850,000.00 | 7,000,000.00 |
| 1.4.11 | Шуудан холбооны зардал | 5,209,075.05 | 6,627,960.00 |
| 1.4.12 | Шатахууны зардал | 26,371,379.57 | 33,976,612.00 |
| 1.4.16 | Бусад зардал | 205,243,960.94 | 367,596,541.00 |
| 1.4.30 | Үйл ажиллагааны зардлын дүн | 1,672,788,999.95 | 1,956,568,741.00 |
| 1.5 | Үндсэн үйл ажиллагааны ашиг алдагдал | (1,851,320,476.69) | (2,015,724,567.37) |
| 2.1 | Үндсэн бус үйлдвэрлэл үйлчилгээний ашиг алдагдал | 324,437,927.84 | 860,550,087.64 |
| 2.8 | Бусад | (669,372,549.60) | (1,517,468,501.38) |
| 2.20 | Үндсэн бус үйл ажиллагааны ашиг алдагдлын дүн | (344,934,621.76) | (656,918,416.62) |
| 3 | **Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал** | **(2,196,255,098.45)** | **(2,672,642,983.99)** |
| 6 | **Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал** | **(2,196,255,098.45)** | **(2,672,642,983.99)** |

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

| | Үзүүлэлт | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Дахин үнэлгээний нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг /алдагдал/ | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **3,384,431,409.00** | **-** | **10,852,595,172.91** | **29,948,203,269.61** | **(14,990,352,683.84)** | **29,194,877,167.68** |
| 2 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - | - |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 3,384,431,409.00 | - | 10,852,595,172.91 | 29,948,203,269.61 | (14,990,352,683.84) | 29,194,877,167.68 |
| 4 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | 300,000.00 | 5,876,132,893.15 | - | 5,876,432,893.15 |
| 5 | Тайлант үеийн цэвэр ашиг | - | - | - | - | (2,196,255,098.45) | (2,196,255,098.45) |
| 6 | Ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| 7 | Гаргасан хувьцаат капитал | - | - | - | - | - | - |
| **8** | **2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **3,384,431,409.00** | **-** | **10,852,895,172.91** | **35,824,336,162.76** | **(17,186,607,782.29)** | **32,875,054,962.38** |
| 9 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - | - |
| 10 | Залруулсан үлдэгдэл | 3,384,431,409.00 | - | 10,852,595,172.91 | 35,824,336,162.76 | (17,186,607,782.29) | 32,875,054,962.38 |
| 11 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - | - | - |
| 12 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | 756,566,120.11 | 1,054,903,274.46 | - | 1,811,469,294.57 |
| 13 | Тайлант үеийн цэвэр ашиг | - | - | - | - | (2,672,642,983.99) | (2,672,642,983.99) |
| 14 | Ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| 15 | Гаргасан хувьцаат капитал | - | - | - | - | - | - |
| **16** | **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **3,384,431,409.00** | **-** | **11,609,461,293.02** | **36,879,239,437.22** | **(19,859,250,766.28)** | **32,013,881,372.96** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-** | **-** |
| **1.1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого** | **8,730,746,574.83** | 10,203,248,677.55 |
| 1.1.1 | Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө | 8,719,464,472.23 | 10,151,335,200.31 |
| 1.1.2 | Туслах үйл ажиллагаанаас орсон мөнгө | 11,282102.60 | 51,913,477.24 |
| **1.2** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **(8,775,755,001.18)** | **(10,009,271,183.71)** |
| 1.2.1 | Ажиллагчдад олгосон мөнгө | (2,065,400,333.51) | (2,577,238,432.72) |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | (1,018,200,000.00) | (930,100,000.00) |
| 1.2.3 | Түүхий эд, материал худалдан авахад төлсөн мөнгө | (4,694,149,409.43) | (5,500,564,979.00) |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | (1,140,311.84) | (1,525,636.74) |
| 1.2.10 | Бусад үйл ажиллагааны мөнгөн зардал | (1,041,873,372.75) | (999,842,135.25) |
| **1.20** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(45,008,426.35)** | **193,977,493.84** |
| 3.2 | Банкнаас авсан зээл | 200,000,000.00 | 200,000,000.00 |
| 3.3 | Хүүгийн орлого | - | 27,983.45 |
| 3.7 | Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт | (495,684,862.01) | (318,631,538.01) |
| **3.20** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(295,684,862.01)** | **(118,603,554.56)** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(340,693,288.36)** | **75,373,939.28** |
| 4.1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 361,849,273.08 | 21,155,984.72 |
| 4.2 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 21,155,984.72 | 96,529,924.00 |

### 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| д/д | Зардлын нэр | 2023 он | | | |
|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөө | гүйцэтгэл | зөрүү | хувь |
| 1 | Цалин | 2,131,786,456.12 | 2,071,490,441.54 | (60,296,014.58) | 97.17 |
| 2 | НДШимтгэл | 309,109,036.14 | 327,797,390.28 | 18,688,354.14 | 106.05 |
| 3 | Албан томилолт | 25,222,000.00 | 12,931,591.21 | (12,290,408.79) | 51.27 |
| 4 | Түүхий эд материал | 699,670,057.23 | 730,537,704.39 | 30,867,647.16 | 104.41 |
| 5 | Цэвэрлэгээний материал | 7,744,345.45 | 10,946,474.63 | 3,202,129.18 | 141.35 |
| 6 | Шуудан холбоо | 12,465,000.00 | 21,452,653.49 | 8,987,653.49 | 172.10 |
| 7 | ШТМ | 232,477,371.91 | 237,951,316.52 | 5,473,944.61 | 102.35 |
| 8 | Үндсэн хөрөнгийн элэгдэл | 3,224,373,544.22 | 3,238,455,151.71 | 14,081,607.49 | 100.44 |
| 9 | Бичиг хэрэг | 12,659,927.27 | 7,978,074.77 | (4,681,852.50) | 63.02 |
| 10 | Ус | 16,993,522.20 | 14,896,347.85 | (2,097,174.35) | 87.66 |
| 11 | Дулаан | 40,632,618.00 | 51,696,553.40 | 11,063,935.40 | 127.23 |
| 12 | Цахилгаан | 1,020,336,855.89 | 986,306,433.10 | (34,030,422.79) | 96.66 |
| 13 | Хоол, унаа | 230,220,000.00 | 208,468,090.91 | (21,751,909.09) | 90.55 |
| 14 | Хөдөлмөр хамгаалал | 247,829,779.82 | 270,331,047.01 | 22,501,267.19 | 109.08 |
| 15 | Сургалт дотоод | 8,810,000.00 | 900,000.00 | (7,910,000.00) | 10.22 |
| 16 | Аваарын хоол | 31,740,000.00 | 31,335,700.00 | (404,300.00) | 98.73 |
| 17 | Нөөц сан | 8,500,000.00 | 4,453,808.66 | (4,046,191.34) | 52.40 |
| 18 | Бусдаар гүйцэтгүүлэх | 93,358,614.64 | 94,541,116.62 | 1,182,501.98 | 101.27 |
| 19 | Зар сурталчилгаа | 7,800,000.00 | 13,241,571.00 | 5,441,571.00 | 169.76 |
| 20 | Хамгаалах салаа | 47,514,960.00 | 37,509,431.50 | (10,005,528.50) | 78.94 |
| 21 | Зээлийн хүүгийн зардал | 19,422,732.16 | 19,254,346.41 | (168,385.75) | 99.13 |
| 22 | Зохицуулах үйлчилгээний төлбөр | 25,000,000.00 | 19,996,000.00 | (5,004,000.00) | 79.98 |
| 23 | Татвар | 22,135,769.00 | 23,074,013.17 | 938,244.17 | 104.24 |
| 24 | Төслийн ажил | 5,000,000.00 | 175,454.54 | (4,824,545.46) | 3.51 |
| 25 | Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн зардал | - | 26,385,644.23 | 26,385,644.23 | |
| 26 | Зулзагын амралт | - | 496,166.00 | 496,166.00 | |
| 27 | Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 3,139,030,682.00 | 3,474,037,241.63 | 335,006,559.63 | 110.67 |
| **БАЙГУУЛЛАГЫН НИЙТ ЗАРДАЛ** | | **11,619,833,272.00** | **11,936,770,483.37** | **316,937,211.70** | |
| | **ОРЛОГО** | | | | |
| 1 | Усны борлуулалтын орлого | 8,402,818,779.21 | 8,403,577,411.95 | 758,632.74 | 100.01 |
| 2 | Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 804,475,509.68 | 860,550,087.77 | 56,074,578.09 | 106.97 |
| | **ОРЛОГЫН ДҮН** | **9,207,294,288.89** | **9,264,127,499.72** | **56,833,210.83** | 100.62 |
| | **АШИГ, АЛДАГДАЛ** | **(2,412,538,983.20)** | **(2,672,642,983.99)** | **(260,104,000.79)** | 110.78 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар хамтын гэрээгээр гүйцэтгэж байгаа дуусаагүй ажлын урьдчилгаа төлбөр 4,153.9 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд авлагаар тайлагнасан алдаа[1] илэрсэн нь УСНББОУС 1-ийн “1-155”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул урьдчилж төлсөн зардал дансанд залруулав.

Мөн албан тушаал хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл цалингийн хэм хэмжээг баталж, байгууллагын дотоод журамд тусгаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 19,804.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд зөвлөмж өгөв.

**5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно

**5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нэмэгдэл цалин хөлс

*Илрүүлэлт:*

Албан тушаал хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл цалингийн хэм хэмжээг баталж, байгууллагын дотоод журамд тусгаагүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 103.3 дахь заалт “Ажил олгогч хууль тогтоомж, хамтын хэлэлцээрт нийцүүлэн цалин хөлсний талаарх дараах хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг баталж мөрдүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Албан тушаал хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл цалингийн хэм хэмжээг тогтоож, байгууллагын дотоод журамд тусгах

2. Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Тайлант онд байгууллагын хэлтэс, албадын дунд монгол киноны хэсгээс дүрсжүүлсэн контент бэлтгэхэд 7,050.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т *“Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”* гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дүгээр зүйлийн 15.1.4-т заасны дагуу байгууллагын хөрөнгөөр урлагийн дүрсжүүлсэн контент, уран бүтээлийн санхүүжүүлэхгүй байх.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой

*Илрүүлэлт:*

Аймгийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнд 2,000.0 мянга, оюутан залуучуудын дунд зохион байгуулсан e-sport тэмцээнд 3,000.0 мянга, бусад тэмцээнд 1,500.0 мянга, биеийн тамирын хувцас бэлтгэхэд 6,254.0 мянган төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "*хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"* гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дүгээр зүйлийн 15.1.3-т заасны дагуу спортын уралдаан тэмцээнд дэмжлэг үзүүлэх, тамирчдын спортын хувцас хэрэглэлд хөрөнгө зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[3]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

[3] .Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруул аагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажил гүйлгээг дансанд буруу бүртгэсэн | 1 | 4,153.9 | - | - | - | - | 1 | 4,153.9 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **4,153.9** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **4,153.9** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Албан тушаал хавсран гүйцэтгэж байгаа нэмэгдэл цалин хөлсний хэм хэмжээг баталж байгууллагын дотоод журамд тусгаагүй. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Байгууллагын хэлтэс, албадын дунд монгол киноны хэсгээс дүрсжүүлсэн контент бэлтгэхэд | 1 | 7,050.0 | - | - | - | - | 1 | 7,050.0 | - | - | - | - |
| Аймгийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн, оюутан залуучуудын дунд зохион байгуулсан e-sport тэмцээн, биеийн тамирын хувцас бэлтгэхэд нийт 12,754.0 мянган төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. | 1 | 12,754.0 | - | - | - | - | 1 | 12,754.0 | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **19,804.0** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **19,804.0** | **-** | **-** | **-** | **-** |
| **Нийт дүн** | **3** | **19,804.0** | **-** | **-** | **-** | **-** | **3** | **19,804.0** | **-** | **-** | **-** | **-** |